



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **БӨА-2025/138/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын,
дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigul@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат
Утас: 70007275 Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗӨСТ	Зоонозын өвчин судлалын төв
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС-	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМҮЗ	Эрүүл мэндийн үндэсний зөвлөл



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**ТОЛБО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Х. МОЛДАБЕК ТАНАА**

2024.02.24 № 175
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь 2024 онд 1,439.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,318.2 сая төгрөг зарцуулж, 91.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

839502000204

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилго, 8 зорилтын хүрээнд нийт 49 арга хэмжээ 95.6 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	112,436,678.17	279,530,335.28
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,447,373.29	242,068.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,447,373.29	242,068.00
3121	Төгрөг	18,447,373.29	242,068.00
31211	Төрийн сангийн харилцах	18,447,373.29	242,068.00
33	АВЛАГА	27,344,443.00	181,778,783.65
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	27,344,443.00	181,778,783.65
35	БАРАА МАТЕРИАЛ	66,644,861.88	97,509,483.63
351	Түүхий эд материал	33,086,016.64	60,296,846.03
35130	Эм боох материал	33,086,016.64	60,296,846.03
354	Хангамжийн материал	33,558,845.24	37,212,637.60
35410	Бичиг хэргийн материал	1,089,000.00	3,189,000.00
35420	Аж ахуйн материал	26,860,910.24	30,234,798.30
35460	Хүнсний материал	5,608,935.00	3,788,839.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,069,109,352.42	1,372,483,118.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,069,109,352.42	1,372,483,118.78
392	Биет хөрөнгө	1,065,148,019.11	1,368,215,285.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	827,646,007.60	941,203,970.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,206,807.48)	(54,298,318.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	79,000,522.00	244,299,361.49
39204	Хуримтлагдсан элэгдэл	(62,514,650.52)	(37,224,955.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	318,437,389.93	312,572,974.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	(117,856,807.43)	(114,315,946.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хопшил	102,360,622.80	93,993,170.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,493,257.87)	(23,514,971.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,500,000.00	24,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,724,999.92)	(18,999,999.88)
393	Биет бус хөрөнгө	3,961,333.31	4,267,833.26
39303	Бусад биет бус хөрөнгө	4,874,000.00	4,874,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(912,666.69)	(606,166.74)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,181,546,030.59	1,652,013,454.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	31,309,234.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	31,309,234.18
413	Өглөг	00.00	31,309,234.18
4136	Бусад өглөг	00.00	31,309,234.18
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	31,309,234.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,181,546,030.59	1,620,704,219.88
51	Засгийн газрын хувь оролцоо	1,181,546,030.59	1,620,704,219.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	228,845,545.08	228,845,545.08
51101	Өмч:- төрийн	228,845,545.08	228,845,545.08
512	Хуримтлагдсан үр дүн	645,172,943.79	1,084,331,133.08
51210	Өмнөх үеийн үр дүн	645,172,943.79	645,172,943.79
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	439,158,189.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	307,527,541.72	307,527,541.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,181,546,030.59	1,652,013,454.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,414,555,991.77	1,824,244,779.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	433,486,720.48	369,773,378.95
120	Нийтлэг татварын бус орлого	433,486,720.48	369,773,378.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	433,486,720.48	369,773,378.95
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	433,486,720.48	369,773,378.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	981,069,271.29	1,454,471,400.16
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,401,700.00	33,838,768.27
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,401,700.00	33,838,768.27
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	945,667,571.29	1,420,632,631.89
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	945,667,571.29	1,420,632,631.89
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,017,348,166.11	1,385,086,589.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,017,348,166.11	1,385,086,589.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,015,695,263.11	1,385,086,589.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	623,501,499.00	960,143,105.00
210101	Үндсэн цалин	381,003,396.00	509,309,657.00
210102	Нэмэгдэл	172,164,909.00	321,618,248.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,641,000.00	25,990,000.00
210104	Урамшуулал	62,692,194.00	103,225,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,644,400.00	116,728,000.00
210201	Тэтгэврийн даатгал	54,838,400.00	78,637,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,451,600.00	9,599,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,161,100.00	4,814,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,290,200.00	4,814,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,903,100.00	18,862,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,188,297.00	40,573,737.27
210301	Гэрэл, цахилгаан	2,765,805.00	4,085,745.27
210302	Түлш, халаалт	28,422,492.00	36,487,992.00
2104	Хангамж, бараа материалын зардал	69,451,412.00	71,952,850.00
210401	Бичиг хэрэг	6,096,650.00	6,380,900.00
210402	Тээвэр, шатахуун	43,053,750.00	51,046,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,080,000.00	3,284,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	525,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,022,432.00	11,000,200.00
210408	Бараа материал акталсны зардал	5,673,580.00	00.00
2105	Нормативт зардал	140,710,841.00	97,495,829.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,176,091.00	78,876,913.32
210502	Хоол, хүнс	13,500,250.00	10,918,915.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,034,500.00	7,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,246,500.00	8,028,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	60,000.00	18,000.00
210604	Урсгал засвар	4,186,500.00	8,010,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,804,000.00	4,968,000.00
210702	Дотоод албан томилолт	2,804,000.00	4,968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	638,400.00	2,783,480.00

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	35,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,960.00	79,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	38,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	526,000.00	770,000.00
210807	Газрын төлбөр	31,440.00	60,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,509,914.11	82,413,388.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,715,010.00	5,853,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,794,904.11	76,559,788.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,652,903.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,652,903.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,652,903.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>397,207,825.66</u>	<u>439,158,189.29</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	953,724,828.29	1,300,037,059.51
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	953,724,828.29	1,300,037,059.51
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,401,700.00	33,838,768.27
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,401,700.00	33,838,768.27
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	918,323,128.29	1,266,198,291.24
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	918,323,128.29	1,266,198,291.24
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	928,620,499.00	1,295,462,464.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	928,620,499.00	1,295,462,464.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	926,967,596.00	1,295,462,464.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	623,501,499.00	960,143,105.00
210101	Үндсэн цалин	381,003,396.00	509,309,657.00
210102	Нэмэгдэл	172,164,909.00	321,618,248.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,641,000.00	25,990,000.00
210104	Урамшуулал	62,692,194.00	103,225,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,644,400.00	116,728,000.00
210201	Тэтгэврийн даатгал	54,838,400.00	78,637,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,451,600.00	9,599,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,161,100.00	4,814,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,290,200.00	4,814,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,903,100.00	18,862,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,840,797.00	31,048,768.27
210301	Гэрэл, цахилгаан	2,765,805.00	4,085,745.27
210302	Түлш, халаалт	28,074,992.00	26,963,023.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,734,100.00	70,465,850.00
210401	Бичиг хэрэг	7,010,650.00	7,369,900.00
210402	Тээвэр, шатахуун	43,053,750.00	51,046,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,080,000.00	3,584,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	525,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,064,700.00	8,224,200.00
2105	Нормативт зардал	112,327,290.00	95,507,461.53
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,303,400.00	78,999,841.53
210502	Хоол, хүнс	15,084,390.00	8,807,620.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,939,500.00	7,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,462,100.00	6,853,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	60,000.00	1,718,000.00
210604	Урсгал засвар	4,402,100.00	5,135,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,804,000.00	4,968,000.00
210702	Дотоод албан томилолт	2,804,000.00	4,968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	638,400.00	2,783,480.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	35,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,960.00	79,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	38,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	526,000.00	770,000.00
210807	Газрын төлбөр	31,440.00	60,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,015,010.00	6,964,600.00

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,015,010.00	6,964,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,652,903.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,652,903.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,652,903.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	25,104,329.29	4,574,594.71
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	32,065,500.00	22,779,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,065,500.00	22,779,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	32,065,500.00	22,779,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	32,065,500.00	22,779,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(32,065,500.00)	(22,779,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(6,961,170.71)	(18,205,305.29)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,408,544.00	18,447,373.29
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,447,373.29	242,068.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	228,845,545.08	307,527,541.72	247,965,118.13	784,338,204.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	228,845,545.08	307,527,541.72	247,965,118.13	784,338,204.93
Тайлант үеийн үр дүн	-	-	397,207,825.66	397,207,825.66
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	228,845,545.08	307,527,541.72	645,172,943.79	1,181,546,030.59
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	228,845,545.08	307,527,541.72	645,172,943.79	1,181,546,030.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	228,845,545.08	307,527,541.72	645,172,943.79	1,181,546,030.59
Тайлант үеийн үр дүн	-	-	439,158,189.29	439,158,189.29
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	228,845,545.08	307,527,541.72	1,084,331,133.08	1,620,704,219.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,439,269,500.00	1,318,242,364.80	121,027,135.20	91.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,439,269,500.00	1,318,242,364.80	121,027,135.20	91.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,439,269,500.00	1,318,242,364.80	121,027,135.20	91.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	985,445,900.00	960,143,105.00	25,302,795.00	97.4
210101	Үндсэн цалин	533,226,000.00	509,309,657.00	23,916,343.00	95.5
210102	Нэмэгдэл	340,018,700.00	321,618,248.00	18,400,452.00	94.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,976,000.00	25,990,000.00	(17,014,000.00)	289.5
210104	Урамшуулал	103,225,200.00	103,225,200.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,555,800.00	116,728,000.00	5,827,800.00	95.2
210201	Тэтгэврийн даатгал	83,337,900.00	78,637,800.00	4,700,100.00	94.4
210202	Тэтгэмжийн даатгал	9,804,500.00	9,599,400.00	205,100.00	97.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,902,200.00	4,814,400.00	87,800.00	98.2
210204	Ажилгүйдлийн даатгал	4,902,200.00	4,814,400.00	87,800.00	98.2
210205	Эрүүл мэндийн даатгал	19,609,000.00	18,862,000.00	747,000.00	96.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,057,300.00	31,048,768.27	40,008,531.73	43.7
210301	Гэрэл, цахилгаан	3,164,800.00	4,085,745.27	(920,945.27)	129.1
210302	Түлш, халаалт	65,892,500.00	26,963,023.00	38,929,477.00	40.9
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	-	2,000,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	84,779,900.00	70,695,850.00	14,084,050.00	83.4
210401	Бичиг хэрэг	8,040,700.00	7,369,900.00	670,800.00	91.7
210402	Тээвэр, шатахуун	60,959,900.00	51,046,950.00	9,912,950.00	83.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,968,000.00	3,584,800.00	383,200.00	90.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	746,600.00	240,000.00	506,600.00	32.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,064,700.00	8,454,200.00	2,610,500.00	76.4
2105	Нормативт зардал	128,297,800.00	95,507,461.53	32,790,338.47	74.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	105,963,800.00	78,999,841.53	26,963,958.47	74.6
210502	Хоол, хүнс	14,379,300.00	8,807,620.00	5,571,680.00	61.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,954,700.00	7,700,000.00	254,700.00	96.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,314,600.00	29,403,100.00	1,911,500.00	93.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,920,000.00	11,277,000.00	1,643,000.00	87.3
210602	Тавилга	6,500,000.00	6,352,900.00	147,100.00	97.7
210604	Урсгал засвар	11,894,600.00	11,773,200.00	121,400.00	99.0

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	5,104,000.00	4,968,000.00	136,000.00	97.3
210702	Дотоод албан томилолт	5,104,000.00	4,968,000.00	136,000.00	97.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,277,900.00	2,783,480.00	494,420.00	84.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00	1,800,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	35,600.00	35,600.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	81,000.00	79,400.00	1,600.00	98.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,000.00	38,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,211,800.00	770,000.00	441,800.00	63.5
210807	Газрын төлбөр	111,500.00	60,480.00	51,020.00	54.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,436,300.00	6,964,600.00	471,700.00	93.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,436,300.00	6,964,600.00	471,700.00	93.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,439,269,500.00	1,300,037,059.51	139,232,440.49	90.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73,989,300.00	33,838,768.27	40,150,531.73	45.7
132001	Орон нутгийн төсвөөс	73,989,300.00	33,838,768.27	40,150,531.73	45.7
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,365,280,200.00	1,266,198,291.24	99,081,908.76	92.7
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,365,280,200.00	1,266,198,291.24	99,081,908.76	92.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		18,447,373.29	(18,447,373.29)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		242,068.00	(242,068.00)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36	37	(1)	102.8
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	29	29	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	6	7	(1)	116.7

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, чанартай хүртээмжтэй, чирэгдэл хүлээгдэлгүй үр дүнтэй үзүүлэхэд оршино.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/
- Засгийн газрын 2024.02.28-ний өдрийн Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84 дүгээр тогтоол,
- Засгийн газрын 2024.03.27-ний өдрийн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 05 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 06 дугаар тогтоол.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд мэргэжлийн байгууллагуудаас ямар нэгэн хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн даргын 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 19 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 470,467.4 мянган төгрөгөөр буюу 39.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,447.3	242.0	18,235.3
Авлага	27,344.4	181,778.7	154,434.3
Бараа материал	66,644.8	97,509.4	30,864.6
Үндсэн хөрөнгө	1,069,109.3	1,372,483.1	303,373.8
Нийт хөрөнгө	1,181,546.0	1,652,013.4	470,467.4
Өр төлбөр	-	21,784.2	21,784.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,181,546.0	1,630,229.2	448,683.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,181,546.0	1,652,013.4	470,467.4

Дээрх хүснэгтээс харахад, дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 18,447.3 мянган төгрөг байсан ба Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,266,198.2 мянга, орон нутгаас 33,838.7 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулсан. Үүнээс ажилчдын цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 960,143.1 мянга, ажил олгогчоос НДШ-д 116,728.0 мянга, байр ашиглалтай холбоотой тогтмол зардалд 33,838.7 мянга, хангамж, бараа материалын зардалд 70,465.8 мянга, норматив зардалд 95,507.4 мянга, эд хогшил урсгал засварын зардалд 29,633.1 мянга, дотоод албан томилолтод 4,968.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 2,783.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 6,964.6 мянган төгрөгийг тус тус зарцуулж тайлант онд дансанд 242.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй үлдсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 181,778.7 мянган төгрөгийн авлагатай ба байгууллагуудад төлөх 31,309.2 мянган төгрөгийн өглөгтэй гарсан. Үүний 9,524.9 мянган төгрөг нь халаалтын өглөг ба Агайын ХХК нь дулаан нийлүүлэх үнэ тарифын асуудалтай байсан ба сумын төрийн сангаас санхүүжилт өгөөгүйтэй холбоотой. Агайын ХХК нь тариф нэмэгдүүлэхээр өгсөн санал нь Баян-Өлгий аймгийн Зохицуулах зөвлөлийн 2024 оны 04 сарын 29-ний өдрийн 24/12 тоот тогтоолоор хүчингүй болсон учраас хуучин тарифаар дулааны жилийн тооцооллыг хийж Агайын ХХК-д шилжүүлсэн мөнгө хоёрын зөрүүгээр өр үүсгэж тайланд тусгасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,418,774.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 53,951.4 мянга, нийт зарлагыг 1,472,725.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 5,080.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 634.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20,037.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь тариф нэмэгдүүлэх санал өгсөнтэй холбоотой, хангамж, бараа материалын зардлыг 6,287.0 мянга, норматив зардлыг 664.9 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 2,863.4 мянга, томилолт, зочны зардлыг 1,496.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 157.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,723.1 мянга, бусад урсгал шилжүүлгийг мянган төгрөгөөр бууруулж, 1,397,667.5 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн хэмнэлт гаргахыг зорьсонтой холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 32,262.3 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрийн 80302 арга хэмжээг санхүүжүүлэхээр 920,071.3 мянга, 81603 арга хэмжээг санхүүжүүлэхээр 445,208.9 төгрөгийг улсын төсвөөс, 73,989.3 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжилтээс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр ЭМД-ын сангаас 1,266,198.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 33,838.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, оны эхний үлдэгдлээс 18,205.3 мянган төгрөгийг зарцуулж, нийт 1,318,242.3 мянган төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна. Зарцуулагдаагүй үлдсэн 242.0 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,318,242.3 мянган төгрөг буюу 91.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 25,302.7 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 5,827.8 мянга, байр ашиглалттай холбоотой зардлыг 40,008.5 хангамж, бараа материалын зардлыг 14,084.0 мянга, норматив зардлыг 32,790.3 эд хогшил, урсгал засварын зардлыг 1,911.5 мянга, томилолтын зардлыг 136.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 494.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 471.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
1.1	80302 Нэг иргэнд ноогдох норматив	920,071.3	916,805.9	3,265.4	99.7
1.2	81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	445,208.9	367,597.7	77,611.2	82.6
2	71601 Нийгмийн эрүүл мэнд				
2.1	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	73,989.3	33,838.8	40,150.5	45.7
	Нийт	1,439,269.5	1,318,242.4	121,027.1	91.6

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 91.6 хувийн биелэлттэй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 оны төсвийн жилд 193,334.5 мянган төгрөгийн бараа материал, 22,279.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авалтын хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор цалингийн нэмэгдэл урамшуулал, үндсэн хөрөнгийн бүртгэл болон баримт баталгаажуулалт, Төрийн хэмнэлтийн хуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Лайт энд Дилайт Аудит” ХХК-ийн аудитор Л.Мөнхцэцэг гүйцэтгэж, аудитын менежер Ц.Төмөрсүх, компанийн захирал М.Нурболат нар анхан шатны чанарын хяналтыг, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,017,348.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,260.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 191 мэдээллээс 132 мэдээллийг хугацаанд нь байршуулсан ба Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 34 удаагийн 1,305,850.1 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 29 удаагийн 1,096,195.5 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон, 1 удаагийн 12105.2 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон ба шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 85.2 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээллийг нөхөж байршуулан зөрчлийг арилгуулах зөвлөмж хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 15,750.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн нь 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	15,750.0	1	15,750.0	100.0
Нийт дүн	1	15,750.0	1	15,750.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар эмийн тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар илэрсэн 12,105.2 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч ажилласан.

5.1 Зөвлөмж

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт: Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨБАҮХАТ)-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5 "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 45 дугаар зүйлийн 45.3. "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна", Засгийн газрын 2025 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Заглуулаагүй		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	
Байхгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

мянган төгрөг

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

мянган төгрөг

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 34 удаагийн 1305850.1 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээ 29 удаагийн 1096195.5 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон, 1 удаагийг 12105.2 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.	1	12,105.2	-	-	-	-	1	12,105.2
ДҮН	1	12,105.2	-	-	-	-	1	12,105.2

мянган төгрөг